



ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙ БАГА ХУРАЛ 2025

Уушги тоосжих өвчнөөс сэргийлье!

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Монголын хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбооноос 2025 оны 10 дугаар сарын 7, 8-ны өдрүүдэд **Хөдөлмөрийн эрүүл ахуй-2025 бага хурлыг “Уушги тоосжих өвчнөөс урьдчилан сэргийлье”** уриан дор зохион байгуулах гэж байна. Хөдөлмөрийн эрүүл мэндийн салбарт ажиллаж өөрийн хувь нэмрээ оруулж байгаа та бүхнийг эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд оролцохыг урьж байна.

Эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааны зорилго: Хөдөлмөрийн эрүүл мэндийн салбарт тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замыг шинжлэх ухаанч нотолгоонд суурилсан мэдээлэлд үндэслэн тодорхойлох, цаашид судалгаа, шинжилгээний ажил, бүтээл, судлаачдын тоог нэмэгдүүлэх, хөдөлмөрийн эрүүл мэндийн чиглэлээр хийгдэх судалгааны идэвх санаачлагыг дээшлүүлэхэд энэхүү уралдааны зорилго оршино

Илтгэлийн сэдвийн хамрах хүрээ:

- Хөдөлмөрийн эрүүл ахуй
- Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлал ба хөдөлмөрийн анагаах ухаан
- Хөдөлмөрийн хор судлал
- Хөдөлмөрийн эрүүл мэндийн хууль тогтоомж ба стандартчилал
- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент

Илтгэл хүлээн авах хугацаа:

- Илтгэлийн хураангуйг 2025 оны 09 дүгээр сарын 10-ны 18:00 цаг хүртэл доорх холбоосоор бүртгэж, хүлээн авна.
- <https://forms.gle/9Da3jjeJdAxoUuzP8>

Илтгэлийн шалгаруулалт:

I шат: Та бүхний илгээсэн илтгэлүүдийг шүүгчдийн бүрэлдэхүүнд илгээж шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлүүлэн амаар хэлэлцүүлэх илтгэлийг шалгаруулна.

II шат: Эхний шатанд шалгарсан илтгэлүүдийг 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр “Хөдөлмөрийн эрүүл ахуй-2025” бага хурал дээр амаар хэлэлцүүлж, шилдэг илтгэлийг шалгаруулна.

Илтгэлд тавих ерөнхий шаардлага:

- Шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны арга зүйг ашиглан хийгдсэн судалгаа байх ба үндэслэл, зорилго, арга зүй, үр дүн, дүгнэлт гэсэн агуулгатай байна.
- Илтгэлийн хураангуйг Arial шрифтээр, 11pt (size) хэмжээтэй 320 үгэнд багтаан бичнэ.

Илтгэлийн хураангуйн бүтэц:

1. Илтгэлийн нэр: Arial шрифтээр, том үсгээр (UPPERCASE), 11 pt (size) хэмжээтэй, Bold
2. Судалгааны багийн гишүүдийн нэр, харьяалагдах байгууллага: Arial шрифтээр, 10pt (size) хэмжээтэй, italic

Жишээ нь:

А.Ааа¹, Б.Ббб²

¹МХЭАҮХ, Судалгааны баг

²Аж ахуйн нэгж байгууллагын нэр

3. Дэд гарчиг: Arial шрифтээр, 11pt (size) хэмжээтэй, зүүн тал руу (align left) шахсан байна.
 - Үндэслэл
 - Зорилго
 - Арга зүй
 - Үр дүн
 - Дүгнэлт
 - Түлхүүр үг
4. Эх бичвэрийг бичихдээ догол мөрнөөс (tab-1cm) эхэлж бичих бөгөөд мөр хоорондын зай 1.5, Arial шрифтээр, ердийн загвартай (regular style), 10pt (size) хэмжээтэй, баруун зүүн талуудыг тэгшилсэн (Justified) байна.

Шагнал, урамшуулал

- | | |
|--------------------|---------------------------|
| • Тэргүүн байр | Өргөмжлөл, 2 сая төгрөг |
| • Дэд тэргүүн байр | Өргөмжлөл, 1.5 сая төгрөг |
| • Тусгай байр | Өргөмжлөл, 1 сая төгрөг |

Лавлах утасны дугаар, имэйл хаяг: (+976) 80070107, conference@mnaoh.mn